



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 11/25

Мандалговь

Г Дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын /а/, “Монгол хэлний тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 265 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Үндэсний бичиг” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Уралдааны шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх уралдааныг зохион байгуулахад шаардагдах 765,000 /долоон зуун жаран таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



020000350